# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
# ШАРГА СУМЫН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 04 өдөр Дугаар А/46 Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Р.Оюунчимэг /ЗДТГ-ын дарга/

Нарийн бичгийн дарга: Н.Гэрэлмаа /Санхүүгийн албаны дарга/

Гишүүд: Д.Ончимэг /ДАШБХ мэргэжилтэн/

Б.Гэрэлт-Од /Газрын даамал/

Б.Оюунтүлхүүр /БОХУ-ын байцаагч/

Б.Гантулга /НЭҮТ-ийн мэргэжилтэн/

Г.Ган-Очир /Баянгол багийн Засаг дарга/

2. Жагсаалтыг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал, 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан зааврыг баримтлан үйлдэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА [illegible].ТУНГАЛАГТАМИР

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 04 өдөр Дугаар А/47 Баянгол

2017 оны 2 дугаар ээлжийн
цэрэг татлагын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт,Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/120 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Р.Оюунчимэг /ЗДТГ-ын дарга/

Гишүүд: С.Цогзолмаа / ЭМТ-ийн эрхлэгч эмч

Т.Гэндэнсүрэн /Хэсгийн төлөөлөгч /

Г.Ган-Очир / Баянгол багийн Засаг дарга /

Ж.Эрдэнэпүрэв /Хамтын хүч багийн Засаг дарга /

Ц.Даваадорж / Сондуулт багийн Засаг дарга /

Б.Гантулга /Улаан туг багийн Засаг дарга /

2. Цэрэгт татагдсан иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, татлагын товчооны үзлэгт биеэр оролцохыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч /С.Цогзолмаа/-д даалгасугай.

3. Эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлсэн талаар авсан арга хэмжээг танилцуулахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч /С.Цогзолмаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА М.ТУНГАЛАГТАМИР

88

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
# ШАРГА СУМЫН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/48 Баянгол

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5 дахь хэсэг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын тоо бүртгэл явуулах журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Гишүүд: Б.Оюунтүлхүүр /БОХУ-ын байцаагч /

Г.Болормаа /Цаг уурын ажилтан /

Э.Гонгбаатар /Эрчим хүчний ажилтан /

Б.Шинэхүү /Байгаль хамгаалагч /

2. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг чанартай зохион байгуулж тайлант нэгтгэн 2017 оны 10 дугаар сарын 30-ны дотор Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Х.Төртулга/-д даалгасугай.

3. Тоо бүртгэлийн ажилд ач холбогдол өгч хариуцлагатай ажиллан тайланг хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА М.ЧИНГЭЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700137

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 24 өдөр Дугаар А/49 Баянгол

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Сондуулт багийн “Хар эрэг”-ийн гүн өрмийн худгийн засварын ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Х.Төртулга /Засаг даргын орлогч /

Гишүүд: Н.Гэрэлмаа /Санхүүгийн албаны дарга/

Л.Оюунбилэг /Нягтлан бодогч/

Ц.Даваадорж /Сондуулт багийн засаг дарга/

Г.Бүрэнтөгс /Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга/

Б.Батжав /Сондуулт багийн иргэн/

2. Ажлын гүйцэтгэлийг ажлын даалгаврын дагуу хүлээн авахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА М.ТУНГАЛАГТАМИР